

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ “АЛДАР СПОРТ ХОРОО”-НЫ 80 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫГ
УГТАН ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ
“АЛДАРЫН ЦОМ-2025” ТАЕКВОНДОГИЙН
НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО:

- Таеквондогийн спортыг сурталчлах
- Монгол улсад олимпын таеквондогийн спортыг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудад таеквондогийн спортоор хичээллэх ач тусыг таниулах
- Баг тамирчдын ур чадварыг дээшлүүлж, харилцан туршлага солилцох

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Ерөнхий зохион байгуулагч	Алдар спорт хороо
Хамтран зохион байгуулагч	Монголын таеквондогийн холбоо
Холбоо барих утас	7015-5500, 9696-2288, 9191-0824
Имэйл	mongoliataekwondo@gmail.com
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Спортын төв ордон

ТӨЛӨВЛӨГӨӨТ ХУВААРЬ:

Огноо	Хөтөлбөр	Байршил
11 сарын 01-10	Бүртгэл	www.mongol-taekwondo.com
11 сарын 14	Техникийн зөвлөгөөн	Алдар спорт хороо
	Жин үзэлт	
11 сарын 15-16	Тэмцээн	

- ❖ Бүртгэл хаагдсаны дараа тэмцээний дэлгэрэнгүй хуваарь нийтэд зарлагдах ба тэмцээнд оролцогчдын тооноос хамаарч өдөрт өөрчлөлт орж болзошгүй.
- ❖ Бүртгэл хаагдсаны дараа оролцогч тамирчдын жин үзүүлэх байршил болон хугацааг олон нийтэд мэдээллэнэ.

ШААРДЛАГА:

Тэмцээнд оролцогч **Тамирчдад** Монголын таеквондогийн холбооны дүрэм, журмын дагуу дараах шаардлага тавигдана.

1. Оролцогч тамирчин Монголын таеквондогийн холбоо болон Кукивионы ямар нэг зэрэг, дантай байна. Тэмцээний үеэр зөвхөн тэр бүсээ бүсэлж тухайн бүсний ангилалдаа өрсөлдөнө.
2. Тамирчин нь Монголын таеквондогийн холбооны цахим бүртгэлийн системд бүртгүүлсэн байх шаардлагатай байх ба хүчинтэй лицензтэй байна
3. Тамирчид шилбэ, шуу, эмзэг эрхтний хамгаалалт DAEDO болон KPNP цахим мэдрэгчтэй оймсыг бэлдэж ирэх шаардлагатай
4. Тэмцээнд оролцогч нь Монголын таеквондогийн холбооны стандартад нийцсэн өмсгөл өмсөнө

Багт тавигдах шаардлага:

1. Тэмцээнд оролцох байгууллага нь Монголын таеквондогийн холбооны албан ёсны гишүүн байгууллага байна
2. Оролцогч байгууллага нь татвар, хураамжийн үлдэгдэл тооцоогүй байх
3. Нэг байгууллагаас орох тамирчны тоонд хязгаарлалт тавихгүй
4. Тэмцээнд оролцогч багууд тамирчдынхаа байр, хоолыг өөрсдөө хариуцна
5. Тулаан А (хар бүстэй тамирчид), В (улаан, цэнхэр бүстэй тамирчид), С (ногоон, шар бүстэй тамирчид) гэсэн үндсэн гурван ангиллаар явагдана. Насанд хүрэгчид бүсний ангилалгүй явагдана.
6. А ангиллын тулаан KPNP цахим онооны системээр, В ангиллын тулаан DAEDO цахим онооны системээр явагдах бол С ангиллын тамирчдын тулаан цахим бус энгийн хамгаалалт дээр явагдана.
7. Бага нас, өсвөр үеийн тамирчид тулааны үеэр нүүрний касктай тулалдана
8. Залуучууд, насанд хүрэгчдийн тамирчид тулааны үеэр нүүрний хамгаалалтгүй шүдний хамгаалалттай тулалдана.
9. Шүдний хамгаалалтын хувьд өнгөгүй тунгалаг эсвэл цагаан өнгөтэйгөөс бусад өнгөтэй шүдний хамгаалалт зүүхийг хориглоно.
10. С ангиллын тамирчид энгийн хамгаалттай тулалдах ба цээж, толгой болон нүүрний хамгаалалтыг багууд өөрсдөө бэлдэж ирэх ба DAEDO болон KPNP цээж, толгойн цахим хамгаалалтыг тэмцээн зохион байгуулагч тал хариуцна.

Дасгалжуулагчид тавигдах шаардлага:

1. Монголын таеквондогийн холбооны дасгалжуулагчийн В зэрэгтэй эсвэл олон улсын дасгалжуулагчийн эрх бүхий дасгалжуулагч тамирчдыг дэвжээнд авч гарах эрхтэй
2. Хагас шигшээ болон шигшээ тулааны үеэр дасгалжуулагчид албаны хувцас өмсөх шаардлагатай
3. Тэмцээнд оролцохоор хүрэлцэн ирэх, буцах замд болон тэмцээний үеэр хариуцсан тамирчдынхаа аюулгүй байдалд хяналт тавих нь тухайн багийн дасгалжуулагчийн үүрэг
4. Тэмцээний үеэр дасгалжуулагч нь ямар ч төрлийн малгай өмсөхийг хориглоно

1. ЖИНГИЙН ДАРААЛАЛ:

Бага нас 8-9 нас (2016-2017) онд төрсөн тамирчид:

Эр		Эм	
-24 кг	24 кг хүртэлх	-23 кг	23 кг хүртэлх
-26 кг	24 кг жингээс 26 кг жингийн хооронд	-25 кг	23 кг жингээс 25 кг жингийн хооронд
-28 кг	26 кг жингээс 28 кг жингийн хооронд	-27 кг	25 кг жингээс 27 кг жингийн хооронд
-30 кг	28 кг жингээс 30 кг жингийн хооронд	-29 кг	27 кг жингээс 29 кг жингийн хооронд
+30 кг	30 кг жингээс дээш жинтэй тамирчид	+29 кг	29 кг жингээс дээш жинтэй тамирчид

Бага нас 10-11 (2014-2015) онд төрсөн тамирчид:

Эр		Эм	
-26 кг	26 кг хүртэлх	-25 кг	25 кг хүртэлх
-29 кг	26 кг жингээс 29 кг жингийн хооронд	-28 кг	25 кг жингээс 28 кг жингийн хооронд
-32 кг	29 кг жингээс 32 кг жингийн хооронд	-31 кг	28 кг жингээс 31 кг жингийн хооронд
-35 кг	32 кг жингээс 35 кг жингийн хооронд	-34 кг	31 кг жингээс 34 кг жингийн хооронд
-38 кг	35 кг жингээс 38 кг жингийн хооронд	-37 кг	34 кг жингээс 37 кг жингийн хооронд
+38 кг	38 кг жингээс дээш жинтэй тамирчид	+37 кг	37 кг жингээс дээш жинтэй тамирчид

Өсвөр үе (12-14 нас) 2011-2013 онд төрсөн тамирчид:

Эр		Эм	
-33 кг	33 кг хүртэлх	-29 кг	29 кг хүртэлх
-37 кг	33 кг жингээс 37 кг жингийн хооронд	-33 кг	29 кг жингээс 33 кг жингийн хооронд
-41 кг	37 кг жингээс 41 кг жингийн хооронд	-37 кг	33 кг жингээс 37 кг жингийн хооронд
-45 кг	41 кг жингээс 45 кг жингийн хооронд	-41 кг	37 кг жингээс 41 кг жингийн хооронд
-49 кг	45 кг жингээс 49 кг жингийн хооронд	-44 кг	41 кг жингээс 44 кг жингийн хооронд
-53 кг	49 кг жингээс 53 кг жингийн хооронд	-47 кг	44 кг жингээс 47 кг жингийн хооронд
-57 кг	53 кг жингээс 57 кг жингийн хооронд	-51 кг	47 кг жингээс 51 кг жингийн хооронд
-61 кг	57 кг жингээс 61 кг жингийн хооронд	-55 кг	51 кг жингээс 55 кг жингийн хооронд
-65 кг	61 кг жингээс 65 кг жингийн хооронд	-59 кг	55 кг жингээс 59 кг жингийн хооронд
+65 кг	65 кг жингээс дээш жинтэй тамирчид	+59 кг	59 кг жингээс дээш жинтэй тамирчид

Залуучууд (15-17 нас) 2008-2010 онд төрсөн тамирчид:

Эр		Эм	
-45 кг	45 кг хүртэлх	-42 кг	42 кг хүртэлх
-48 кг	45 кг жингээс 48 кг жингийн хооронд	-44 кг	42 кг жингээс 44 кг жингийн хооронд
-51 кг	48 кг жингээс 51 кг жингийн хооронд	-46 кг	44 кг жингээс 46 кг жингийн хооронд
-55 кг	51 кг жингээс 55 кг жингийн хооронд	-49 кг	46 кг жингээс 49 кг жингийн хооронд
-59 кг	55 кг жингээс 59 кг жингийн хооронд	-52 кг	49 кг жингээс 52 кг жингийн хооронд
-63 кг	59 кг жингээс 63 кг жингийн хооронд	-55 кг	52 кг жингээс 55 кг жингийн хооронд
-68 кг	63 кг жингээс 68 кг жингийн хооронд	-59 кг	55 кг жингээс 59 кг жингийн хооронд
-73 кг	68 кг жингээс 73 кг жингийн хооронд	-63 кг	59 кг жингээс 63 кг жингийн хооронд
-78 кг	73 кг жингээс 78 кг жингийн хооронд	-68 кг	63 кг жингээс 68 кг жингийн хооронд
+78 кг	78 кг жингээс дээш жинтэй тамирчид	+68 кг	68 кг жингээс дээш жинтэй тамирчид

Насанд хүрэгч (18 болон түүнээс дээш) 2007 оноос өмнө төрсөн тамирчид:

Эр		Эм	
-54 кг	33 кг хүртэлх	-46 кг	46 кг хүртэлх
-58 кг	54 кг жингээс 58 кг жингийн хооронд	-49 кг	46 кг жингээс 49 кг жингийн хооронд
-63 кг	58 кг жингээс 63 кг жингийн хооронд	-53 кг	49 кг жингээс 53 кг жингийн хооронд
-68 кг	63 кг жингээс 68 кг жингийн хооронд	-57 кг	53 кг жингээс 57 кг жингийн хооронд
-74 кг	68 кг жингээс 74 кг жингийн хооронд	-62 кг	57 кг жингээс 62 кг жингийн хооронд
-80 кг	74 кг жингээс 80 кг жингийн хооронд	-67 кг	62 кг жингээс 67 кг жингийн хооронд
-87 кг	80 кг жингээс 87 кг жингийн хооронд	-73 кг	67 кг жингээс 73 кг жингийн хооронд
+87 кг	87 кг жингээс дээш жинтэй тамирчид	+73 кг	73 кг жингээс дээш жинтэй тамирчид

2. БҮРТГЭЛ:

- I. Бүртгэлийн хугацаа: 2025 оны 11 сарын 1-10-ны 18:00 цаг хүртэл
- II. Бүртгэлийг цахимаар хийх ба Монголын таеквондогийн холбооны албан ёсны бүртгэлийн систем болон www.mongol-taekwondo.com хаягаар бүртгүүлнэ.

3. ОРОЛЦОГЧИЙН ХУРААМЖ:

- Улаанбаатар хотын тамирчид дэвжээний төлбөр 50.000 (тавин мянга)
- Улаанбаатар хотоос 1000 км дотогш тамирчид дэвжээний төлбөр 40.000 (дөчин мянга)
- Улаанбаатар хотоос 1000 км гадагш тамирчид дэвжээний төлбөр 30.000 (гучин мянга)

3.1 Оролцогчийн хураамж хүлээн авах данс:

Банк: Хаан

Хүлээн авагч: Х.Билгүүн

Дансны дугаар: 70000500 5402266888

4. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

1. Хувь тамирчин:

- Жин тус бүрд 1-р байр нэг, 2-р байр нэг, 3-р байр хоёр тамирчин шалгаруулан медаль, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

2. Баг:

- Багийн дүнг медалийн чанараар дүгнэнэ.
- В,С ангилал тус бүрд эхний гурван байр эзэлсэн багуудыг цом, медалиар шагнаж урамшуулна.
- А ангилалд багийн дүнгээр тэргүүн байр эзэлсэн багт цом, медаль, 5.000.000 төгрөгийн мөнгөн шагнал, дэд байр эзэлсэн багт цом, медаль, 3.000.000 төгрөгийн мөнгөн шагнал, гутгаар байр эзэлсэн багт цом, медаль, 2.000.000 төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

3. Шилдэг дасгалжуулагч, шилдэг шүүгч, шилдэг эрэгтэй, эмэгтэй тамирчин тус бүр 1 шалгаруулан шагнаж урамшуулна.

5. ӨМСГӨЛ:

- Монголын таеквондогийн стандартад нийцсэн өмсгөл өмсөн тэмцээнд оролцох шаардлага тавигдах хэдий ч багийн нэр, логог /ивээн тэтгэгчийн/ тулааны өмсгөл болон жигдрэлийн хувцсан дээр хадахыг зөвшөөрнө.
- Тэмцээний өмсгөлийн стандарт



6. БАГИЙН АХЛАГЧДЫН УУЛЗАЛТ БОЛОН СУГАЛАА

1. Багийн ахлагч нар 11 сарын 14-ний өдөр хуралдана.
2. Багийн ахлагчдын уулзалтад тэмцээнд оролцох багууд төлөөллөө оролцуулах үүрэгтэй.

7. ЖИН ҮЗЭЛТ

1. Оролцогчдын үндсэн жинг 11 сарын 14-ний өдөр үзнэ.
2. Жин тус бүрд заасан жиндээ багтах орох хэрэгтэй ба заасан жингээс 100 гр илүү жинтэй байх тохиолдолд жиндээ орж чадахгүй хасагдана. Жиндээ орж чадаагүй тамирчин дээд жиндээ орж болохгүй буюу зөвхөн мэдүүлэгт өгсөн жиндээ орох шаардлагатай.

- ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО -